


СУМЫН ЗАСАГ ДАРГА



Э.НАСАНЦОГТ

2019 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

Өвөрхангай аймгийн Баян-өндөр сумын засаг даргын тамгын газар

БАЯН-ӨНДӨР СУМЫН 2019 ОНД СПОРТ ЗААЛНЫ ТОХИЖИЛТ БАРАА
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

БУМБАТ

2019 он

**Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын
Засаг даргын Тамгын газар**

**БАЯН-ӨНДӨР СУМЫН 2019 ОНД СПОРТ ЗАЛНЫ ТОХИЖИЛТЫН БАРАА
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**БАЯН-ӨНДӨР СУМЫН 2019 ОНД СПОРТ ЗАЛНЫ
ТОХИЖИЛТЫН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АЖ
АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар:

№ӨВАБАӨСЗДТГ/201912002

БУМБАТ

2019 ОН

Тендер шалгаруулалтын нэр: Спорт залны тохижилт

Тендер шалгаруулалтын дугаар: ӨВАБАСЗДТГ/201912002

Огноо: 2019-05-15

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газарт спорт залны тохижилтод бараа бүтээгдэхүүн нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Гадаадын иргэн тендер ирүүлэх эрхтэй эсэх: үгүй

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Байгууллагын нэр: Өв. Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн 15 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн 15 цаг 30** минутад нээнэ.

Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын

Засаг даргын Тамгын газар 10 тоот,

Утас: 99884180

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдоод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (a) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ

захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.





| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|----------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 1 /нэг/ жилийн санхүүгийн тайлан /2018 оны санхүүгийн тайлан/ - Борлуулалтын орлогын хэмжээ сүүлийн 1 жилийн борлуулалтын орлогын хэмжээ санал болгож буй үнийн дүнгээс дээш байх - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ /санал болгож буй үнийн дүнгээс дээш байх/ - Сүүлийн /1 жилийн/ туршлагын талаар мэдээлэл ирүүлэх гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар , хугацаа дуусаагүй байх /Нотариатаар батлуулсан байх/ - Байгууллагын танилцуулга баталгаажсан байх - Хугацаа хэтэрсэн өр зээлгүй гэсэн харилцагч банкны тодорхойлолт - Татварын тодорхойлолт https://e-tax.mta.mn/ сайтаас хэвлэсэн, бар кодтой, тендер нээсэн өдрөөр хугацаа хэтэрсэн өргүй байх. - Шүүхийн тодорхойлолт - Барааны баталгаат хугацаа 1 жил байх - Барааг нийлүүлэхтэй холбогдон гарах төлбөр хураамж, татварыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна. - Тусгай зөвшөөрөл шаардахгүй - Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаар мэдээлэл ирүүлэх жилийн тоо. Сүүлийн 1 жил /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар ирүүлэх/ - Тендерийн баримт бичиг хуулийн 14-16 дугаар зүйл шаардаг хангасан байх - Тендерт оролцогч нь тендерийн материалыг захиалагчид ирүүлэхдээ хуудас бүрийг дугаарлаж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулагдсан байх. |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерт оролцогч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-г хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 2. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг</p> |

| | |
|----------|---|
| | <p>хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, 10 тоот, Утас: 99804180</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 30 минут</p> |
| ТӨӨЗ 6.1 | <p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p> |



1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

| Нэр | Тодорхой лолт | Тоо ширхэг | Х / н | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|--|-------------------------------|------------|----------|--|---|--|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| <i>Спорт залны тохижилтын бараа материал</i> | <i>Спортын хэрэглэгдэхүүн</i> | 53 | <i>ш</i> | <i>Баян-Өндөр сумын төв</i> | <i>Гэрээ хийсэн өдрөөс</i> | <i>Дараа оны тендер зарлагдах хүртэл</i> | |

Техникийн тодорхойлолт

| Багцийн дугаар | Бараа болон холбогдох үйлчилгээний нэр | Техникийн тодорхойлолт болон стандарт |
|-----------------------|---|--|
| | <i>Спортын хэрэглэгдэхүүн</i> | - Стандартын шаардлага хангасан байх - Чанарын баталгаатай байх |

1. Бүтээгдэхүүн нь гарал үүслийн бичигтэй байх
2. Бараа бүтээгдхүүний үнэ нь тухайн суманд мөрдөгдөж байгаа зах зээлийн хамгийн бага дундаж үнэ байх
3. Хугацаа дууссан бүтээгдэхүүн, чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хэрэглэгчийг хохиролгүй болгоно гэсэн албан ёсны баталгаа ирүүлэх
4. Бүтээгдэхүүний хэмжээг тодорхой зааж ирүүлэх
5. Чанар, стандартад нийцсэн барааг Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын спорт заланд суурилуулан хүлээлгэн өгсөн байх

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН СПОРТ ЗАЛНЫ ТОХИЖИЛТОД НИЙЛҮҮЛЭХ
БАРАА МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Remove Watermark Now

2019 он

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Аль улсад үйлдвэрлэсэн | Чанар, үзүүлэлт даац | Өнгө | хэмжээ |
|----|--|------------|----------------|----------|---|---|-----------------|---|
| 1. | Үзэгчийн сандал | 8 | 1444375 | 11555000 | 5*5 квадрат /6,0м/ 5*5 квадрат /0,4м/ 5*5 квадрат /0,8/ 5*3-тай брус /6,0м/ 5*3 брус /1,4м/ Босоо 7 дайтай байх. | Төмөр замыг гагнаж, прусс модыг зүлгүүрдэж, шрупдэж замаскдсан байх | 2 давхар лакдах | Багана хоорондын зай 6 метрээр 2 шатлалтай хийх, 1-р сандлын h-35 см тавцангийн өргөн 30 см 2-р сандлын h-55 см тавцангийн өргөн 30 см |
| 2 | Тамирчдын хувцас солих сандал | 4 | 100000 | 400000 | 5*5 квадрат/3,0м / 5*5 квадрат/0,4м / 5*5 квадрат/0,8/ 5*3-тай брус /3,0м | Төмөр замыг гагнаж, прусс модыг зүлгүүрдэж, шрупдэж замаскдсан байх | 2 давхар лакдах | Үзэгчийн сандлаас тусдаа тавигдах 3 метрийн урттай. сандлын h-40 см тавцангийн өргөн 60 см нэг тал нь хувцас хийх зориулалттай хаалгатай байна. |
| 3. | Шүүгчийн ширээ | 1 | 250000 | 250000 | Сайн чанарын хавтангаар стандартын шаардлага хангасан байх | Удаан хэрэглэгдэхээр Гар аргаар хийх. Өнгө үзэмж сайтай байх | Бор шаргал | 2 метрийн урттай. |
| 4. | Дасгал Жуулагчийн ширээ, сандал, хувцасны шкаф | 1 | 200000 | 400000 | Албан хэргийн шаардлага хангасан байна. | Стандартын шаардлага хангасан байх | Шаргал | 180 см-ийн урттай |
| 5 | Сандал | 10 | 90000 | 900000 | Хятад улсад үйлдвэрлэсэн сайн чанарын сандлуудтай дүйцэхүйц | Төмөр хөлтэй, арчиж цэвэрлэхэд хялбархан бат бөх байх | хар | |
| 6 | Чанга яригч | 2 | 600000 | 1200000 | Япон улсын Ямаха брендтэй дүйцэхүйц | Яригч – 1500w чанга яригч – 2 | Хар саарал | 1500w |

| | | | | | | | | |
|----|--|----|--------------------|---------|---|---|---------------|----------------------------------|
| 7 | пульт | 1 | 250000 | 250000 | | Пульт Чадлын өсгөгч | Хар саарал | 1500w |
| 8 | Микро фон, утасгүй 2ш, уртас гагч залгуур 1 ширхэг | 2 | 120000 | 240000 | | Микрофоны утас 6 м -2ш Утасгүй микрофон 2ш Ком залгуур 10 м хос | | Толгой нь shur байвал сайн |
| 9 | Бөмбөг /волей вол/ | 10 | 120000 | 1200000 | Сайн чанарын арьсан бөмбөг | Бөмбөгний жин 260- 280г бөмбөгний бүслүүр 65- 67см сайн чанарын арьсан бөмбөг байх. | | |
| 10 | Бөмбөг /сагс/ | 10 | 100000 | 1000000 | | Бүслүүр 76,2-81,3 см хэмжээтэй сайн чанарын арьсан бөмбөг байх | | |
| 11 | Бөмбөг хадгал даг сагс | 1 | | 120000 | | Сагсанд бөмбөгөө хийгээд түрээд явдаг сагс | | |
| 12 | Гар бөмбөг ний шүүгчий н сандал | 1 | | 235000 | | Шаттай шүүгчийн сандаг | | |
| | дүн | | 20000000-00 | | /Хорин сая төгрөг/ Барааг Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын спорт зааланд суурилуулж хүлээлгэн өгөх/ | | | |

Барааг хүргэх газар хуваарийн дагуу чанар стандартад нийцсэн барааг Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын спорт зааланд суурилуулж хүлээлгэн өгөх.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН СПОРТ ЗАЛНЫ ТОХИЖИЛТОД
НИЙЛҮҮЛЭХ БАРАА МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Remove Watermark Now

2019.05.15

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|----|--|--------------------|------------|-------------|--|---|--------------------------|--------------------------------------|
| | | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1. | Үзэгчийн сандал | Стандартад тохирох | 8 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 2 | Тамирчдын хувцас солих сандал | Стандартад тохирох | 4 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 3. | Шүүгчийн ширээ | Стандартад тохирох | 1 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 4. | Дасгалжуулагчийн ширээ, сандал, хувцасны шкаф | Стандартад тохирох | 3 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 5 | Сандал | Стандартад тохирох | 10 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 6 | Чанга яригч | Стандартад тохирох | 2 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 7 | пульт | Стандартад тохирох | 1 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 8 | Микрофон, утасгүй 2ш, уртасгагч залгуур 1 ширхэг | Стандартад тохирох | 2 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 9 | Бөмбөг /волейбол/ | Стандартад тохирох | 10 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 10 | Бөмбөг/сагс/ | Стандартад тохирох | 10 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |
| 11 | Бөмбөг хадгалдаг | Стандартад | 1 | ш | Баян-Өндөр сумын төв | 2019-06-05 | 2019-06-15 | |

| | | | | | | | | |
|----|--|---------------------------|---|---|--|------------|------------|--|
| | сагс | тохирох | | | Спорт зааланд бараа нийлүүлэх | | | |
| 12 | Гар бөмбөгний шүүгчийн сандал | Стандарт ад тохирох | 1 | ш | Баян-Өндөр сумын төв Спорт зааланд бараа нийлүүлэх | 2019-06-05 | 2019-06-15 | |



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ****1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|--------------------|------------------------|-------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |



Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежер хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

 (Тамга, тэмдэг)

 (Тамга, тэмдэг)

 (Гарын үсэг)

 (Гарын үсэг)

 (Албан тушаал)

 (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 Бусад шаардлагатай баримт бичиг;
 Үнийн санал;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
 [Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
 [Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
 [Утас/факсын дугаар]
 [Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
 [Утас/факсын дугаар]
 [Харилцагч банкны нэр, дансны дугаар]